



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2020 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 02/01

Эрдэнэт


Орхон аймгийг хөгжүүлэх
таван жилийн үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.2 "а", 18.1.2 "е" дэх заалтууд, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

2.Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг жил бүрийн IV улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг дарга С.Батжаргалд даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ